

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-20

- 1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/ 4-5
- 2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 5-20

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 10 дугаар сарын 25-ны
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 41 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, Х.Ганхуяг, Т.Доржханд.

Байнгын хорооны дарга Э.Батшугар Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Э.Батшугар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Э.Батшугар: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 4
Бүгд: 6
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Э.Батшугар дээрх санал хураалтыг хүчингүйд тооцох санал хэлэв.

Э.Батшугар: Дээрх санал хураалтыг хүчингүйд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2

Бүгд: 6
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Э.Батшугар: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, шинжээч Н.Уранцэцэг, мэргэжилтэн Б.Очиртогтох, Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн М.Мөнгөнхүлэг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Р.Хангал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн ахлах шинжээч Н.Сансармаа, Санхүү, төсвийн судалгааны газрын ахлах шинжээч З.Анар, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Ч.Золбаяр, Б.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Насанбат, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Инновацын бодлогын газрын дарга Т.Золзаяа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох, “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Дагвасүмбэрэл, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Ц.Хосжаргал, П.Чанцалдулам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ц.Сэргэлэн, Ч.Ундрам, Э.Батшугар нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Ч.Золбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Насанбат, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 10 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 11 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
10 цаг 41 минут

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Э.Батиугар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдэд сонгогдсон тойрог нэрээр танилцуулъя.

28 дугаар тойрог Батиугар, 12 дугаар тойрог Ганибал, 18 дугаар тойрог Идэрбат, 28 дугаар тойрог Учрал, 23 дугаар тойрог Чинбүрэн, 13 дугаар тойрог Ундрал.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа.

1 дүгээр асуудал. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл төслүүд.

2 дахь асуудал. Монгол Улсын Их Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудал. Цаглавар батлах тухай. Байнгын хорооны тогтоолын төсөл.

Үүн дээр эхлээд санал хураалтаа явуулъя. Цаглавараа баталчихъя гэдэг санал хураалт явуулчихвал яаж байна. Дарааллаа өөрчлөөд, болж байна уу?

Тэгвэл эхлээд Байнгын хорооны цаглавараа батлах санал хураалт явуулах. Дараалал өөрчлөх санал явуулъя.

66,7 хувиар дэмжигдлээ.

Сая санал хураалтаа баталсны дагуу эхлээд цаглавараа баталъя.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудал. Цаглавар батлах тухай.

Тогтоолын төслүүд та бүхэнд гар тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Сая техникийн алдаа гарсан байна. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгоё. Хүчингүй болгох санал хураалт явуулъя.

66,7 хувиар түрүүчийн санал хураалт хүчингүй боллоо. |

Тэгэхээр түрүүн уншсан цаглавраа батлах санал хураалтаа ахиад явуулъя. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар 66,7 хувиар батлагдлаа.

10.46 цаг

Одоо 2 дугаар асуудал руугаа оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгээ оруулах уу. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Н.Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд, Д.Занданбат Монгол Улсын Ерөнхий аудитор, С.Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Н.Уранцэцэг Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, М.Мөнгөнхүлэг Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Б.Очиртогтох Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Н.Сансармаа Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн ахлах шинжээч, З.Анар Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын ахлах шинжээч, С.Гэлэгжунай Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Ч.Золбаяр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Х.Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлогын төлөвлөлтийн газрын дарга, Б.Билигдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийн

зохицуулах газрын дарга, Э.Насанбат Цахим хөгжил, харилцаа холбоо яамны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Т.Дэлгэрмаа Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, С.Цагаанхүү Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Шуудан өргөн нэвтрүүлгийн хэлтсийн дарга, П.Батбаатар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга, Т.Золзаяа Эдийн засгийн хөгжлийн яамны Инновацын бодлогын газрын дарга, М.Баттулга Үндэсний дата төвийн УТҮГ-ын захирал, Б.Мягмарнаран И-Монголиа академи УТҮГ-ын захирал.

Монгол улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Ням-Осорын Учрал сайд танилцуулна. Уучлаарай. Б.Жавхлан Сангийн сайд танилцуулна.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний арван жилийн зорилт болох Шинэ сэргэлтийн бодлогоо хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс Шинэ сэргэлтийн бодлогын

гол зорилтын нэг болох “Хот хөдөөгийн сэргэлт”-ийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан.

Энэ хүрээнд инновац, цахим хөгжлийг хурдасгахад чиглэсэн арга хэмжээ, тухайлбал, экспортыг нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгоход чиглэсэн цахим шилжилтийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгаад байна.

Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих багц, арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25.3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27.4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2.1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2.8 хувь болж, төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Ирэх оны төсөвт инновац, цахим хөгжлийн чиглэлээр тусгасан арга хэмжээтэй танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Э.Батиугар: Жавхлан сайдаа баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөөлөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат дарга танилцуулна. 1 дүгээр микрофоныг нээе. 1 номерын микрофон, 3-ыг нээчихсэн байна.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээнд хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна.

1. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэгт заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-д эзлэх харьцаа 2024 онд 40,7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34,2 хувь, нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу

ДНБ-ий 2,8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, 19 дүгээр зүйлийн 19.9-д 2024 онд 2,8 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх, төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна.

3. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх,

Хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортыг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх,

Иргэдийн орлогыг хамгаалж, цалин, тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх,

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэд эх орондоо

оношлогдон эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх,

Уул уурхайн орлогоос орон нутгийн хөгжлийн санд нэмэлт орлого хуваарилах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах, тогтвортой хариуцлагатай уул уурхайг дэмжиж, байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ.

Боловсрол шинэжлэх ухааны сайд: 5,9 9 тэрбум төгрөг төсвийн орлого төвлөрүүлэх, зардал нь 4 ихт 259 тэрбум төгрөг,

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд: төвлөрүүлэх орлого 8,7 тэрбум, зардал 85,6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зардлын дүн 23 оны тодотгосон төсвөөс 1 их наяд 171,4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 4 их наяд 344,5 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21-д өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан нь улсын төсвөөс санхүүжихээр заасны дагуу зардал нэмэгдсэн. Засгийн газраас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх бодлого баримталсан зэрэгтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилттой нийцэж буй хэдий ч Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнээс БШУЯ 5, Цахим хөгжил, харилцаа

холбооны яам дараах 3 арга хэмжээг тусгаагүй байна.

БШУЯ нь КООСЭН сургалтын хөтөлбөрийг аймаг бүрд мэргэжлийн болон техник боловсролын сургалтад нэвтрүүлэх.

Их, дээд сургуулиудын магистр, докторын судалгааны сэдвийг төрийн болон хувийн хэвшилд хэрэгцээтэй байгаа судалгаа судалгаатай уялдуулах тогтолцоог нэвтрүүлэх.

Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүллэг, бүтээл патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах.

Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэлд бүтээл патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах.

Сургуулийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам. Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер, тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх, цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын төв байгуулах, интернэтийн харилцан холболт, аюулгүй байдлыг сайжруулах зэрэг арга хэмжээг тусгаагүй байна.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад нийт 723,9 тэрбум төгрөгийн 382 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 345,7 тэрбум төгрөгийн 246 төсөл, арга хэмжээ тусгагдсан 387,2 тэрбум төгрөгийн 136 төсөл, арга хэмжээ тусгаагдаагүй байна.

Үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож, хүрэх үр дүнг богино дунд хугацаагаар тодорхойлж, үйл ажиллагааг хэмжсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэж, төлөвлөсөн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулья.

1. Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

3. Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо, судалгааг хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5. Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, 1 маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа, зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт нь бүрэн тусгуулахад анхаарах.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үед

хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх,

Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн, зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх.

Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх ажлыг зохион байгуулах, худалдан авах үйл ажиллагаа, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, Улсын комисс хүлээн авах үйл ажиллагаанд субъектив сөрөг нөлөөлөлгүй байлгах, тодорхой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах, шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч хэрэгжилтэд нь хяналт тавих.

Хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг сайжруулах зэрэгт анхаарах хэрэгтэй байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Э.Батшугар: Баярлалаа.
Занданбат даргад.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн

ерөнхий захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэн хүргүүлсэн байх болно.

Хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхий захирагчдаас асуух асуудалтай гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Ундрам гишүүнээр тасалъя. Идэрбат гишүүний микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ 2024 оны улсын төсөв дээр өнгөрсөн жил хэмнэлтийн хууль хэлэлцэгдэж эхлэхэд л энэ хөдөө, орон нутагт байгаа багуудыг үүрэн холбоонд холбох ажлыг улсын төсвөөс хийлгэж болохгүй гэсэн тэр хуулийн төслийг нь бас хасуулаад л ингээд л ажиллаж байсан хүний хувьд. Мөн одоо энэ орон нутгаар ажиллаж байх үед манай малчид, иргэдээс маш их хэмжээнд яригддаг энэ зүйл бол энэ үүрэн холбооны сүлжээг өргөтгөх, шинээр бий болгох, байгуулах ийм үйл явдал байгаа юм.

Тэгээд өнгөрсөн 2023 оны төсөв дээр тухайн үед улсын төсвөөс тавигдаагүй бүх нийтийн үүргийн сангаас Хэнтий аймгийн нэр бүхий Батноров, Баян-Адарга, Жаргалтхаан гэсэн 3 сум дээр одоо сүлжээ байгуулах энэ саналыг хүргүүлсэн. Тэгээд энэ маань бас тодорхой шалтгааны улмаас хийгдэж чадаагүй гэсэн ийм мэдээлэлтэй байгаа. Тэгэхээр 2024 оны төсөв дээр одоо нийт улсын хэмжээнд 20 тэрбум төгрөг тавиад мөн одоо 10 тэрбум нь одоо ирэх онд санхүүжигдэх ийм хуваарьтай явж байгаа юм байна. Тэгэхээр өнгөрсөн онд хийгдээгүй 3 сүлжээний шалтгаан юу вэ? Тэр шалтгаан 2024 онд бас дахиад үргэлжлэх үү гэдэг зүйлийг бас асууж тодруулъя гэж ингэж бодож байна. Тэгээд бидний хувьд одоо бас нэг ажлын албатай. Тэгээд Хэнтийгээс сонгогдсон Их Хурлын

гишүүд нэр бүхий 12 сумд сүлжээ байгуулах энэ саналыг бас хүргүүлээд, холбогдох хуулийн дагуу бүх жагсаалт юманд нь оруулаад ингээд явуулсан. Тэгэхээр энэ ажил ирэх жил Хэнтийд яг хийгдэх үү?

Э.Батиугар: Хэн хариулах юм? Золбаяр дарга тийшээ суучих уу, та. 3 номерын микрофонд суучихъя. 3 номерын микрофоныг нээе.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Золбаяр байна. Идэрбат гишүүний асуултад хариулъя. Бүх нийтийн үүргийн сангаас 2023 онд 2 удаагийн сонгон шалгаруулалтыг зарласан боловч оператор компаниудаас саналаа илэрхийлээгүй байгаа. Энэ шалтгааныг бид нар нэлээн тодруулж оператор компаниудтайгаа болон дэд бүтцийг хариуцдаг компаниудтайгаа ажиллаж үзсэн байгаа. Энэ дээр 2 үндсэн шалтгаан гарч ирсэн. Нэг нь болохоор 1 дүгээрт, энэ багийн сүлжээн дээр хүн ам суурьшлын бүсэд байж байгаа хүн амын тоо цөөн учраас оператор компаниуд бид нар энэ үүргийн сангаас танай өгч байгаа энэ мөнгөөр бид нар үйлчилгээ явуулахад боломжгүй байна. Өөрөөр хэлбэл нэг багийн төв дээр бааз станц байгуулахад бид нар 400 сая орчим төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж байна. Тэгээд 5 жилийн үүрэг хүлээгээд ажиллахдаа бид нар 600 сая төгрөгийн нийтдээ зардал гарна. Гэтэл үүргийн сангаас өгч байгаа татаасын хэмжээ тэр 60 сая төгрөг 160 сая төгрөг гэдэг чинь ер нь хаанаа ч хүрэхгүй байгаа учраас ийм боломжгүй байна.

Нөгөө талаасаа зүгээр бид нар судалгаа хийж үзэхэд энэ цэгүүд дээр бусад өөр оператор компаниудын сүлжээ орчихсон байна гэдэг ийм асуудлуудыг тавьсан. Энэ юун дээр бид нар дүгнэлт хийгээд ямар ажлыг зохион байгуулсан бэ гэхээр Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас бүх нийтийн үүргийн сангийн дэд бүтэц нь бэлэн болсон байгаа сайтууд дээр нь үүрэн

холбооны оператор компаниуд дээр дахин сонгон шалгаруулалтыг зарласан. Мөн энэ сонгон шалгаруулалт дээр 20 цэг байснаас 14 цэг дээр нь саналаа ирүүлсэн. Бас дахин 5 цэг дээр оператор компаниуд саналаа ирүүлээгүй. Энэ шалтгаан нь дамжуулах байгууламж болон үндсэн сүлжээтэй холбогдох хүртээмжийн асуудлаас болоод энэ дээр саналаа ирүүлээгүй байгаа.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зүгээс энэ төсөв дээр оруулсан энэ дээр ажиллагаа хийсэн байгаа. Энэ нь юун дээр байна гэхээр оператор компаниудтайгаа бид нар уулзаад ер нь хатуу дэд бүтцийг нь улсын төсвөөс бид нар байгуулж өгөөд энэ үйл ажиллагааныхаа орлогыг нөхөж чадахгүй байж байгаа энэ урсгал зардлын асуудлыг нь бүх нийтийн үүрийн сангаас санхүүжүүлэх замаар, харин оператор компаниуд өөрсдийн тоног төхөөрөмжийг байршуулах гэсэн ийм замаар ийм хувилбараар бид нар ер нь үндсэн сүлжээнд холбогдоогүй үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй байгаа багуудаа харилцаа холбооны сүлжээгээр хангая гэдэг ийм бодлогыг дэвшүүлээд Мэдээлэл, харилцаа холбооны операторуудын ассоциациар дамжуулсан оператор компаниудтайгаа хуваалцсан байж байгаа.

Мөн үндсэн сүлжээний дэд бүтэц хариуцдаг компаниудтайгаа ярилцсаны үндсэн дээр ийм хувилбарыг гаргаад одоо энэ төсөв дээр бид нар саналаа оруулаад явчихсан байж байгаа. Улсын хэмжээнд 191 баг үндсэн сүлжээнд холбогдоогүй гэсэн юутай байгаа учраас үүнийг бид ийм байдлаар шийдэх нь зөв өө гэсэн шийдэл гаргасан.

Хэнтий аймгийн хувьд Идэрбат гишүүнээс ирүүлсэн саналын юунд бас харахад болбол Хэнтий аймаг дээр 4 баг дээр сүлжээ оруулах ийм хүсэлтийг ирүүлсэн байгаад байгаа. Манай дээр энэ дээр судалгаагаа хийж үзэхэд Хэнтий аймгийн Мөрөн сумын 2 дугаар баг буюу

Өлзийт баг дээр Жи Мобайлын сүлжээ 20 хувь барьдаг, өөр газар нь ороогүй байгаа гэсэн ийм судалгаа гарсан. Бусад тэр Жаргалтхаан, Баян-Адарга, Батноров гэсэн сумууд нь одоо энэ манай улсын төсөвт тусгагдсан байж байгаа энэ багуудын дэд бүтэц дээр шийдэгдэнэ. Тэгэхээр энэ хүрээнд оператор компани энэ улсын төсвөөр хийгдэх энэ ажлуудын хүрээнд хийгдэнэ гэж ойлгож болно.

Э.Батиугар: Идэрбат гишүүн тодруулъя. 1 минут.

Ц.Идэрбат: Тийм, ер нь яах вэ, Хэнтий аймгийн яг хөдөө сумдын 50-аад багаас 20 гаруй нь сүлжээгүй байгаа юм. Тэгээд энэ дээр бид нар Хэнтий аймгаас сонгогдсон гишүүд энэ 20 тэрбумаас тусдаа 2,9 тэрбум төгрөгийн саналыг улсын төсөв дээр хүргүүлсэн л дээ. Тэгэхээр та өнгөрсөн юмыг ярьж байна л даа. Одоо би танаас асуусан юм нь ирэх оны төсөв дээр бид нар Хэнтий аймгийн Норовлин, Баян-Овоо, Галишар, Мөрөн, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх, Баянхутаг гэсэн нэр бүхий сумууд дээр сүлжээ тавиулъя гэж 2,9-ийг энэ 20-оос тусдаа эд шүү энэ, үүнийг бас ялгаж салгаж ойлгоорой. Энэ 20-доо оруулчхав гэж би зориуд хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр энэ 10 хэдэн сумд хамгийн түрүүнд энэ ажлууд хийгдэх үү? Яагаад гэвэл улсын төсвөөр хөрөнгийг нь тавиулж байгаа.

2 дугаарт, Үүргийн сан гэдэг юмтай холбогдож мөнгө цаас нь хүрэхгүй тэр хүндрэлүүдийг давахын тулд үүнийг ингэж оруулсан байгаа, зөв үү? Та энэ дээр надад нэг тодорхой хариулаад өгөөч.

Э.Батиугар: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Идэрбат гишүүн өмнө жилийн төсөв дээр яг тэр нөгөө Төсвийн хуулийг дагаж орж байхад улсын

төсвөөр энэ алслагдсан баг, сум, суурин газруудын шилэн кабель, үүрэн холбооны сүлжээнд холбохыг шийдэхгүй гэдэг заалтыг бас өөрөө зарчмын санал гаргаж тухайн үед хасуулж байсан. Тэгэхээр үүний үр дүнд бид бас энэ жил энэ улсын төсөв дээр энэ үүрэн холбооны сүлжээ байгуулах тодорхой төсвийг оруулах ийм бас нөхцөл бас бүрдсэн гэж бас хэлж болно. Тэгээд Хэнтий аймаг тухайлан багуудынхаа саналыг өгсөн. Нэг ёсондоо Улсын Их Хурлын 3 гишүүн нь нэгдээд үнэхээр одоо манай аймагт энэ алслагдсан багуудыг холбох шаардлагатай байна гэдгээ багуудынхаа нэрсийг гаргаад жагсаалтыг гаргаад бид нарт хүргүүлсэн. Тэгэхээр энэ өөрөө холбооны сүлжээ байгуулах гээд байгаа одоо шинээр орж ирж байгаа тэр төсөвтөө ... /минут дуусав/

Э.Батиугар: Учрал сайдад 1 минутаар сая өгсөн байна. 4 минутаар өгье.

Н.Учрал: Тийм, тэгэхээр энэ төсөв тусдаа гэж ойлгож болно. Тэгээд үүрэн холбооны сүлжээ байгуулах тэр төсөв дээр түрүүн бас ажлын хэсгээс хариулсан. Ер нь нэг 400 орчим сая төгрөг тэр дэд бүтцийг шийдэхэд зарцуулагдаж байгаа бол түүний яг хатуу дэд бүтцийг нь 150-200 сая төгрөг. Тэр нөгөө уулын орой дээр байрлах уу, хаана нь байрлах вэ гэдгээс шалтгаалаад ялгаатай гарч ирж байгаа, зарим багууд бол. Ингээд хувийн хэвшил буюу тэр оператор компаниуд үүн дээр бас тодорхой 180-200 орчим сая төгрөг зардал гаргаад үүн дээр болбол мөн одоо нөгөө урсгал зардлын асуудал яригдаж байгаа. Одоо тэр сайтыг байгуулаад тэр дэд бүтцийг байгуулаад түүнийг хэн хэрхэн хаана хамгаалж үйл ажиллагааг нь явуулах вэ гээд. Үүн дээр бүх нийтийн үүргийн сангаас тэр урсгал зардлыг нь дэмжчихье ээ. Ингэх юм бол тэр сум, суурин газар, багуудад нөгөө айл өрхийн тоо бага байгаагаас үл хамаараад ажил явуулах бололцоотой болно гэж байгаа. Тэгэхээр яах вэ, зүгээр ер нь үүргийн сан

бас харьцангуй үүргээ биелүүлсэн юм байна. Өнгөрсөн хугацаанд. Нэг 330 сумыг, 1500 багийг ямар нэгэн сүлжээнд оруулсан. Тэгэхээр одоо зарим аймгуудад юу вэ гэхээр нөгөө тэгш хүртээмжийг бий болгохгүйгээсээ болоод зарим аймаг жишээ нь огт сүлжээгүй, аль ч операторын сүлжээ ороогүй байхад зарим аймаг дээр 4 дэх операторыг оруулъя гээд хүсэлт гаргаад явж байдаг. Тэгээд өнгөрсөн хугацаанд үүргийн сан чинь яг үнэндээ хэн их хөөцөлдлөгөөтэй Их Хурлын гишүүдийн ажлыг явуулдаг. Сүүлдээ ер нь тэр ширээ сандал руугаа орчихсон юм байна лээ шүү дээ. Ширээ сандал авч өгдөг болж эхэлсэн. Гэтэл Монгол Улсын хэмжээнд 191 баг бүр огт сүлжээгүй байж байна шүү дээ. Юун 3 дахь, 4 дэх оператор орох нь байтугай, бүр огт сүлжээ байхгүй байж байгаа байхгүй юу. Гэтэл зарим газар өнөөдөр 3 дахь операторын санал, 4 дэх операторын санал, интернэтийн хурд нь удаан байна, 4G болгож өгөөч гэдэг санал ингээд ирээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр тийм дэвшил гарч байгаа.

Тэгэхдээ огт сүлжээгүй байгаа газруудыг ерөөсөө бид нар бас мартаж болохгүй учраас энэ 191 багаа ялгаад бид нар 191 багаасаа зүгээр нэг ирэх жил 100 багийг шийдвэрлэе гэдэг ийм л зорилго тавьсан. Тэгэхээр 100 багийг шийдвэрлэхэд нэг баг дээр 200 сая, хувийн компаниуд дахиад бараг 200 сая, үүргийн сангаас бараг нэг 36, 40 орчим сая төгрөг, урсгал шийднэ гэхээр ингээд хамтын түншлэлээр энэ зохион байгуулагдана. Тэгэхээр одоо ирэх оны төсөв дээр санхүүжих зардал 10 тэрбум гэж тавигдсан байгаа тохиолдолд бид нар 50 багийг л шийднэ гэсэн үг. 100 баг шийдэж чадахгүй. Тэгэхээр 50 багийг эрэмбэлэхдээ гишүүдийн ирсэн санал, одоо нөгөө огт сүлжээнд ороогүй 191 багийгаа эхнээс нь эрэмбэлээд огт сүлжээ ороогүй үнэхээр холбоо харилцаа шаардлагатай байгаа гэснийг нь эрэмбэлээд, шаардлагатай эхний 50-ийг оруулахаас биш зүгээр юу гэдэг юм тэр Их Хурлын гишүүн дээрээс хойш хандсан

юм, олон удаа хандсан юм гэдэг байдлаар биш. Улсын хэмжээнд аль 50 баг нь онц чухал байгаа юм бэ гэдгээ эрэмбэлээд л явна.

Хэрвээ энэ 20 тэрбум төгрөг бүхнээ бүхлээрээ ирэх ондоо гэвэл 100 баг шийдэгдэх буюу ер нь нэг цаашидаа Засгийн газрын зүгээс нэг 2 жилд энэ 200 багийг 191 багийг сүлжээнд бүрэн оруулаад дуусгая л гэсэн ийм зорилтыг тавиад оператор компаниуд, хувийн хэвшилтэйгээ тохиролцоонд бас хүрээд ажиллаж байгаа.

Э.Батшугар: Сэргэлэн гишүүний микрофоныг.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би нэг 2, 3 асуулт байна. Ер нь жилд дунджаар төрийн байгууллагуудын энэ программ хангамжийн зардалд хэдий хэмжээний зардал яг төлөвлөж гаргадаг юм? Эсвэл төлөвлөөгүй ч гэсэн гаргадаг бас зардал байгаа. Би зүгээр дунджийг нь асууж байгаа юм. Нарийвчилсан тоо гаргахад төвөгтэй байх гэж би бодож байна.

Энэ асуулттай холбогдуулаад Монгол Улсын төрийн байгууллагууд өөрсдөө төрийн байгууллагын өөрийнх нь хийсэн программ хангамжаар үйл ажиллагаа явуулж байна уу эсвэл одоо гэрээний үндсэн дээр хувийн ААН-үүдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр энэ программ хангамжуудаа хийлгээд, хөгжүүлээд ингээд явж байна уу? Энэ талаар нэг яг өнөөдрийн байгаа бодитой нөхцөл байдлын талаар нэг мэдээлэл өгөөч гэж хүсэх гэсэн юм.

Ер нь программ хангамжийг хийлгэхээс гадна хийлгээд авлаа, цаашиа түүний хөгжүүлэлт, аюулгүй байдлыг нь хангах асуудлууд гэх мэтчилэн маш их урсгал зардлууд үргэлжлэн гарч байдаг. Техник хангамжаасаа илүү зардал ер нь энэ программ хангамжаар урсгал төсвөөс гараад явдаг. Тэгэхээр энэ талаар ер нь хийсэн анализ, тооцоо юм байна уу? Үүнтэй холбуулаад би

программ хангамжтай холбоод хэлэхэд ер нь ихэвчлэн энэ гадаадын зээл, тусламж одоо хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд дандаа тэр гадаад улсын тухайн субъектүүдийн хараанд, тэдний мэдэлд энэ программ хангамжууд нь хийгдээд явдаг юм болов уу гэж харагдаад байдаг юм. Энэ нь өөрөө эргээд сөрөг талыг авчирдаг. Өөрөөр хэлбэл кибер аюулгүй байдлын талаасаа үүнийг анхаармаар нэг юм харагдаад байдаг юм. Тийм учраас би энэ төрийн байгууллагуудын программ хангамжийн асуудлыг онцгойлон анхаарахгүй болохгүй болсон гэж бодож явдаг хүний хувьд энэ асуултыг асууж байгаа юм.

Дээрээс нь энэ аюулгүй байдлаасаа гадна энэ урсгал төсөв энэ программ хангамжид ёстой урсаж байдаг эд шүү дээ. Үүнийг надад нэг та бүхэн минь мэргэжлийн байгууллага байна, анхаарал хандуулаад хариулаад өгөөч ээ гэж хүсэх гэсэн юм.

2 дугаарт, үгүй ээ, ер нь энэ кибер аюулгүй байдлыг хангах зардлыг төсөв суулгадаг юм уу? Төсвийн зардлын зүйл, ангиудаа хараад байхад ерөөсөө энэнтэй холбоотой зардал байдаггүй юм. Өмнө нь ч байгаагүй. Зарим төрийн байгууллагууд аргаа ядахдаа холбооны зардлаасаа л үүнийг гаргаад явдаг. Одоо өнөөдөр кибер аюулгүй байдлын асуудал эн тэргүүнд тавихгүй бол болохоо байчхаад байгаа шүү дээ. Хакерууд хил хязгааргүй болчихсон, гэмт этгээдүүд өөрсдийнхөө зорилгод хүрэхийн тулд энэ цахим ертөнцийг маш өргөн хүрээнд ашигладаг, өндөр түвшиний бүр гайхамшигтай өндөр түвшиний хакеруудыг хөлсөлдөг болчихсон шүү дээ. Энэ тохиолдолд бид энэ кибер аюулгүй байдлын асуудлыг ерөөсөө бодлогоор анхаарч, төсөв мөнгөнөөс нь эхлээд түүнийг хамгаалах асуудлууд, адаглаад л энэ төрийн байгууллага болгон өөр өөрсдөө энэ кибер аюулгүй байдлыг хангах тусгайлсан арга хэмжээнүүдийг авахад томоохон хэмжээний зардлууд шаарддаг. Тэр галт

хананаас эхлээд л одоо хамгийн энгийн жишээ хэлэхэд. Тэгээд энэ дээр нь зориулсан төсвүүдийг нь тавьж өгөхгүй бол кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой төсөв гэдэг асуудлыг яг ярих цаг болчихсон гэж би ер нь хэлэх гээд байгаа юм. Тэгээд энэ дээр та бүхэн минь нэг хариулаад өгнө үү гэж асууя.

Э.Батшугар: Учрал сайдын микрофоныг нээе. Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Та бидний баталсан энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр энэ программ хангамжтай холбоотойгоор зөвлөмж, дүгнэлт гаргах эрхийг энэ Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд уг нь олгосон. Тэгээд 2022 оны 219 дүгээр энэ тогтоолоор нийтдээ ер нь нийтийн мэдээллийн дэд бүтэц, цахим үйлчилгээнд хамаарах цахим энэ төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалт бүртгэлийг нэгдсэн байдлаар баталъя гэдэг ийм шийдвэр гараад өнгөрсөн хугацаанд төрийн захиргааны байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, НЗДТГ нийт, 16 яам, 13 агентлаг, 14 аймаг, дэргэдэх 106 байгууллагаас нийт 2 жилийн хугацаанд 357 төсөл, хөтөлбөрийн 997,8 тэрбум төгрөгөөр нийт одоо программ хангамж, дэд бүтэц хийхэд зарцуулна гэдэг ийм бүртгэлийн мэдээлэл нэгдсэн сан гараад энэ ажил хэрэгжиж байгаа гэсэн үг. 2 жилд бараг 1 их наяд төгрөг хэмжээнд хүрч байна гэсэн үг. Тэгээд бид энэ ажлыг илүү үр дүнтэй болгох ёстой. Өнгөрсөн хугацаанд программ хангамжид мөнгө зарсан, зарсан хэдий ч үр дүнд хүрээгүй. Яагаад гэхээр яам болгон өөрөө нэг төсөл, хөтөлбөр зарладаг, нэг тендер зарладаг, тэгээд хоорондоо огт холбогддоггүй, хоорондоо нэгтгэгддэггүй учраас өнөөдрийн байдалд хүрсэн. Тийм учраас бид нар нэг ийм бүртгэлийн 1 нэгдсэн сантай ямар ч байсан болоод авлаа.

Дээрээс нь энэ яамнууд нэг зөвлөмж, дүгнэлтээ ядаж авч байгааг ээ. Мэргэжлийн яамнаас гээд ингээд

шаардаад бас ажиллаж байгаа. Гэсэн хэдий ч өнөөдөр бас бидний үгийг төдийлөн сонсдог байгууллагууд тийм их биш байгаа, яг үнэндээ. Яагаад гэхээр яам болгон мэдээж өөр өөрсдийн бие даасан систем хөгжүүлдэг болсон. Тэгээд хувийн хэвшилтэйгээ өрсөлддөг. Ингээд бид өнгөрсөн 1 сарын өмнө Засгийн газарт хүсэлт явуулсан. Одоо байгаа мэдээллийн технологийн төвүүд гэж нэрлэж байгаа байгууллагуудад энэ яамдын асуудлуудыг хариуцуулъя.

2-т, Засгийн газрын дэргэдэх ямар ч ай ти төвүүд систем хөгжүүлэхээс татгалзъя. Нэг ёсондоо хувийн хэвшилээрээ хийлгэе. Төрийн байгууллагууд албан даалгавар гаргадаг төслөө удирддаг. Яг одоо төр хэзээ ч барилгыг өөрөө дэргэдэх барилгын компаниараа барилдаггүй. Тендер зарлаад барилчхаад буцаагаад хүлээн авдаг, баталдаг, комисс нь хүлээгээд авдаг шиг цаашаа манай салбар ч ийм л болох ёстой. Ингэж байж хувийн хэвшилээс нэг хэдэн чадамжтай компани бас төрөх юм байна гэдэг зорилтоор ийм Засгийн газрын шийдвэр гарсан. Ингээд одоо энэ олон Ай ти-ийн төвүүд бол борооны дараах мөөг шиг олон болж байна гээд байна шүү дээ. Яам болгон агентлаг болгон дэргэдээ 1, 1 төв байгуулдаг. Хувийн хэвшилээс 1, 1 инженерийг нь татаж авдаг. Бид зөвхөн бодлогоо барья. Цаашидаа ингээд хамтраад ажиллая. Тэгвэл энэ программ хангамжууд чинь бас 1 цэгцтэй болох юм байна гэдэг ийм зорилтоор хууль, эрх зүйн хувьд энэ асуудлуудыг шийдээд явж байгаа. Одоо энэ 120 хуулийн үеэр ч гэсэн энэ асуудал нэлээн бас цэгцдээ орно гэж бид нар найдаж байгаа.

Кибер халдлагын хувьд манай ажлыг ч нэмэх байх. Тэгэхдээ кибер халдлагын хувьд Сэргэлэн гишүүн их чухал асуудлыг хөндөж байгаа юм. Бид нар ниргэсэн хойно нь дандаа хаширдаг болчихсон. Одоо бид нар албан ёсны лиценз авна гээд энд төсөв оруулж ирэхээр тэрийг ойлгодоггүй. Бид нар

ерөөсөө л нэг 3 давхар байрыг л хөрөнгө оруулалт гэж боддог болохоос биш албан ёсны лиценз авах яагаад чухал юм бэ гэдгийг ойлгохгүй учраас лицензэд мөнгө зарахгүй байгаад өнөөдөр хүрчихсэн. Тэгээд төрийн байгууллагууд аргаа барж байгаа шүү дээ. Албан ёсны лиценз авч чадахгүй, албан ёсны харилцаа байхгүй, дандаа одоо нэг ийм байдалтай. Тэгээд халдлагад өртвөл яах вэ гэдэг юман дээр хэн ч хариулж чадахгүй. Тэгээд кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв хуулиар байгуулагдсан байтал энэ нийтийн төвийн төсөв энэ улсын төсөвт орж ирээгүй. Энэ яах вэ дараа болно гээд. Тэгээд цахимжилт хийгээд байдаг, аюулгүй байдал хангагдаагүй л байгаа. Хэн ч хэнээсээ бурууг нэхэж одоо хариуцлага нэхэж чадахгүй.

Э.Батиугар: 3 номерын микрофоныг нээе. 3 номер, 1 номерын микрофоныг нээгээд байна, 3.

Э.Насанбат: Сэргэлэн гишүүний асуултад хариулъя. Кибер аюулгүй байдлын тухай хуулиар заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 02 дугаар сарын 01-ний 42 дугаар тогтоолоор Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албыг байгуулсан байж байгаа. Мөн хуульд заасны дагуу 2023 оны 08 дугаар сарын 30-ны 319 дүгээр тогтоолоор Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийг байгуулах ийм тогтоол гарсан. Энэ нийтийн төв маань хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь төр, хувийн хэвшил болон бусад ААН-үүдийн кибер аюулгүй байдлыг хангах, кибер халдлагад өртсөн тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээ авах, мөн сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах гэсэн ийм үйл ажиллагааг гардан зохион байгуулахаар ингээд зохион байгуулагдчихсан. Одоо ингээд манай яамны бүтцэд ажиллахаар ингээд байгаа.

Халдлага зөрчлийн хувьд ингээд ярих юм бол зөвхөн өнгөрсөн 7 хоногийн тайлан мэдээгээр Монгол улсын

хэмжээнд 38 ай эс ни компанийн 8642 ай ни хаягаас 88576 удаагийн сэжигтэй хандалт илэрсэн байгаа. Энэ сэжигтэй хандлагуудын 53493 нь хорттой код, 28512 нь системд дүрмийн бусаар нэвтрэлт хийхийг оролдсон оролдлого гэж ингэж тайлан гарч ирж байгаа. Энэ тайлан дээрээс энэ дүрмийн бусаар халдсан гэдэг нь зорилтот хакерын түвшний халдлага гэсэн үг. 53 мянга гэдэг нь иргэн, хуулийн этгээд ААН-ийн компьютер буюу гар утсан дээр ямар нэгэн хорттой код суусны улмаас мэдээлэл дамжуулах оролдлого хийгдсэнийг бас илрүүлсэн гэсэн үг юм байгаа юм.

Яг одоо кибер аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хариуцан ажиллаж байгаагийн хувьд хэлэхэд Монгол Улсын хэмжээнд яг энэ кибер халдлага зөрчлийг илрүүлээд таслан зогсоож байгаа бүтэц яг иргэний түвшинд одоогоор байхгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлын газрын бүтцэд байдаг Кибер халдлага зөрчилтэй тэмцэх үндэсний төв энд тодорхой хэмжээнд Засгийн газрын түвшинд үйл ажиллагаагаа байгууллагын түвшинд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Энэ ирж байгаа тайлан мэдээллүүд олон улсын кибер аюулгүй байдлаар хамтарч ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын нэгдлээс 7 хоног тутамд манай ажлын албанд тайлан мэдээгээ ирүүлж байгаа юм. Энэ мэдээллээр ирэхээр энэ 8642 ай ни хаяг бол яг хэн бэ, ард нь хэн байна вэ гэдгийг бид нар илрүүлж тогтоогоод цааш нь хийх дээр бид нарт яг техникийн болоод хүний нөөцийн, бүтцийн ийм асуудал зайлшгүй шаардлагатай болчихсон байгаа. Тэгэхээр одоо энэ чиглэл дээр энэ жилээс Цахим хөгжлийн харилцаа холбооны яам анхаарал хандуулаад ингээд ажиллаад явж байгаа.

Тэгээд төсвийн хувьд ярихад кибер аюулгүй байдлын төсөв ажлын алба үйл ажиллагааны төсөв төсөвт суучихсан байгаа. Харин нийтийн төвийн үйл ажиллагаатай холбоотой төсөв манай

яамны бүтцийн төсөвт суугаагүй байгаа.

Э.Батиугар: Сэргэлэн гишүүн тодруулъя.

Ц.Сэргэлэн: Энэ кибер аюулгүй байдалтай холбоотой буюу аюулгүй байдлаас хамгаалах энэ төсөв суугаагүй байна гэдэг бол туйлын харамсалтай л даа. Эрсдэлийн түвшин ямар байхаас шалтгаалаад асуудал эргээд учрах эрсдэл нь янз бүр л байгаа. Сая таны хариулт дотор тэр эрсдэлийн түвшинээр нь ялгаад халдлагуудыг ангилаад танилцуулж байна. Хакерын түвшиний халдлагууд маш олон удаагийнх хийгдсэн л байна. Хэдэн мянгаараа л явж байна. Тэгээд энэ дандаа зорилготой байгаа шүү дээ. Цаанаа. Ямар нэгэн байдлаар зорилгодоо хүрэх гэж байгаа юм. Тэгэхээр би юу гэж хэлж гэж бодож байна вэ гэхээр онц чухал мэдээллийн сан бүхий төрийн байгууллагуудын, төрийн тусгай байгууллагуудын энэ кибер аюулгүй байдлыг хангах чиглэлийн төсвийг нь та бүхэн цаашидаа анхаараач, онцгой анхаарч байхгүй бол энэ үндэсний аюулгүй байдалд хүртэл заналхийлэх хэмжээний .../минут дуусав/

Э.Батиугар: Сэргэлэн гишүүнд 1 минут.

Ц.Сэргэлэн: Тэгэхээр би яах вэ, нэгэнт одоо бодит байдал ийм байгаа учраас ядаж гэж хэлж байгаа юм. Ядаж онц чухал мэдээллийн сан бүхий төрийн тусгай байгууллагуудынхаа кибер аюулгүй байдалд нь зориулсан төсвийг нь жил болгон төсөвлөж өгдөг. Тэр кибер аюулгүй байдлын төвүүд уг нь байгуулагдаад одоо үйл ажиллагаа нь эхэлж байгаа гэж би ойлгож байгаа юм. Үгүй ээ, тэгээд кибер аюулгүй байдлын төвүүдийнхээ төсвийг тавиагүй байна гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тэгэхээр Засгийн газар Учрал сайд энэ дээр ер нь та цаашидаа бас анхаарал хандуулах нь одоо зөв л болов уу гэж би бодож байна.

Тэгээд ер нь хүсэлт бараг тавьж байна. Ер нь энэ кибер аюулгүй байдлын төвүүдээ яаралтай ажилд оруулаад, төсвийг нь одоо хангалттай өгөөд явах ёстой. Ер нь буу бариад ирэх дайснаасаа илүүтэй энэ кибер аюулгүй байдлын чиглэлээр буюу хакерын халдлага чинь энэ Монгол Улсад аюул занал учруулна шүү. Ер нь аюул занал заналхийлэл гэдэг энэ ухагдахуун чинь өөрөө хамгаалалт гэдэг ухагдахууны салиггүй бүрэлдэхүүн хэсэг. Заавал ... /минут дуусав/

Э.Батиугар: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Сэргэлэн гишүүн их чухал асуудлыг хөндөж байгаа. Кибер аюулгүй байдлын хуулиараа зөвлөлтэй болсон. Ерөнхий сайд ахалж байгаа. Ажлын алба байгуулагдсан. Тайлан мэдээгээ аваад хариу арга хэмжээг өөрсдийнхөө түвшинд аваад явж байгаа. Тэгээд нийтийн төв хуулиараа байгуулагдах ёстой. Тэр хууль хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын шийдвэрээр публич суурьт Нийтийн төв тогтоолоор байгуулагдсан. Бид одоо өөрийнхөө төсвийн багцын хүрээнд дотооддоо зохицуулалт хийгээд л ингээд л нийтийн төвийг эхлүүлж гэж л зорьж байгаа. Ямар ч байсан ажлыг нь эхлүүлнэ. Гэхдээ Цахим хөгжлийн яам бол нэг ч өөрөө бие даасан систем хөгжүүлэх зардал мөнгө тавиагүй шүү. Бид зүгээр худалдан авалт хийгээд, хувийн хэвшилээрээ хийлгээд, ажлыг нь шалгаруулж аваад ингээд явна. Тэгэхээр нийтийн төв ч гэсэн хүн амьтанд олноор нь аваад байхдаа биш. Мэдээж хувийн хэвшил бусад ОУБ-тай хамтраад л ажиллана.

Э.Батиугар: Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Миний хувьд зарчмын асуудал өнөөдөр хөндөх гэсэн юм. Улсын төсвийг Засгийн газар боловсруулаад Улсын Их Хуралд өргөн барьсны дараа тусгай горимоор бид нар хэлэлцдэг. 45 хоног 4 удаагийн хэлэлцүүлэг хийж байж

бид нар улсын төсвийг баталдаг. Тэгээд энэ чинь яагаад ийм тусгай горимоор яваад байгаа юм бэ гэхээр УИХ төсвийг маш сайн нарийвчлан хэлэлцэж байж батлаасай гэсэн тийм л одоо цаана философи яваад байгаа шүү дээ. Тэгээд хэлэлцье. Одоо жишээлбэл энэ танай яаман дээр багцад чинь тавигдсан 10 тэрбум, 20 тэрбум гээд бөөндөө бүхэлдээ тавигдчихсан мөнгө чинь яг юунд зарцуулагдах нь тодорхойгүй байна. Үүнээс нэг хэсгийг нь тодорхой болгоод Сэлэнгэ аймагт тавьчихъя гэхээр Засгийн газрын гишүүн нь өөдөөс бойкотлоод байж болохгүй шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн болж төлөөлж байгаа ард түмнийхээ өмнөөс өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд төсөвтэй холбоотой асуудал хэлж болно, санал гаргаж болно, санал хураалгаж ч болно. Тэгэхээр өөдөөс одоо хэрүүл хийгээд л, бойкотлоод байдаг ийм Засгийн газрын гишүүнтэй байж болохгүй гэж би бодож байна.

Боловсролын сайдыг ялангуяа би одоо боловсролтой байгаасай гэж хүсэж байгаа юм. Сэлэнгийн ард түмэн Монголын ард түмний нэг хэсэг мөн шүү дээ. Тэр хүмүүс чинь боловсролын, соёлын үйлчилгээ авах бүрэн эрхтэй шүү дээ. Тэнд улсын хилээ манайд сууж байгаа цэргийн хүүхэд чанартай боловсролын, соёлын үйлчилгээ авах эрхтэй шүү дээ. Тэгэхээр л тэр асуудлыг хэлээд тавихаар л, элдэвлээд л, янз бүрээр доромжлоод, Сэлэнгийн ард түмэн ажилсаг. Энэ Монголын ХАА-н тулах цэг, Монголчуудыг талх тариатай байлгаж байгаа хүмүүс шүү. Тийм учраас тэнд байгаа хүүхдүүдийн төлөө, ард иргэдийн төлөө үг хэлэхээ хэнээр ч заалгахгүй гэж бодож байна. Ер нь ингэж доромжилсныхоо төлөө Сэлэнгийн ард түмнээс Боловсролын сайд уучлалт гуйх ёстой гэж би бодож байна.

Э.Батиугар: Үг хэллээ.

Би нэг 2, 3 юм асуучихъя. Энэ түрүүн бас гишүүд ярьж байна. Энд онц чухал дэд бүтэцтэй байгууллагуудаа хамгаалахаар ТЕГ-ын доор байгуулагдах Үндэсний төв төсөв нь одоо харагдахгүй байна. Үүн дээр одоо яах вэ хэзээ байгуулагдах вэ? Ямар нэгэн мэдээлэл байна уу? Энэ чинь одоо яг чухал Монголын төрийн байгууллага болон хувийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд, үндэсний аюулгүй байдлыг онц чухал үүрэг хүлээдэг байгууллагуудыг хамгаалах төв байгаа юм. 900-аад мянган иргэд тоон гарын үсэг авсан байгаа, байна. Тэгэхээр энэ тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ямар арга хэмжээ авч байгаа вэ? Энэ тоон гарын үсэг чинь Монгол Улсын иргэнийг цахим системд таних тийм хэрэгсэл. Дэлхийд маш олон улсад идэвхтэй хэрэглэгдэж байгаа.

Мөн Монгол Улсын тоон гаруй үсгийг олон улсын аудитын байгууллагуудаар дүгнэлт гаргуулж, тэгээд олон улсад хүлээн зөвшөөрөгдөх энэ алхам аль түвшиндээ байгаа вэ? ер нь. Төлөвлөгөөнд тусгагдсан уу? Яг үүнтэй холбоотойгоор олон нийтийн мэдээлэл технологийн мэдлэг чухал байна. Ялангуяа одоо ди-парламентын доор ди-өргөдөл гомдлын систем өнгөрсөн 7 хоногоос үйл ажиллагаагаа эхлүүлээд явж байгаа. Үүн дээр ямар нэгэн Их Хурлын харьяанд болон харьяалагдах хүрээнд хууль тогтоомжийн дагуу хэрэглэх асуудлаар Монгол Улсын иргэн шууд өргөдөл өгөх бололцоог нь хийж байгаа юм. Цахимаар. Цахимаар тэр санал өгөхдөө дан систем болон тоон гарын үсгээрээ дамжуулж саналаа өгнө. Тэгэхээр энэ 900 мянган иргэн болон дан системээр өөрийгөө таниулах энэ цахим мэдлэг боловсрол маш чухал. Үүн дээр холбоотойгоор ялангуяа манай ахмад настны иргэд их гомдол. Одоо миний цахим хуудсаар ирүүлсэн. Яаж энэ системд чинь саналаа өгөх юм бэ, сайн ойлгохгүй байна, мэдэхгүй байна гэх мэтчилэн. Тэгэхээр

үүн дээр үүнтэй холбоотойгоор ард иргэдийн цахим мэдлэгийг дээшлүүлэх ямар арга хэмжээ авч байгаа вэ? ШУТ сан жил болгон төсөвтэй болоод явдаг. Мааш олон судалгаа хийдэг л байх. Ямар ямар бүтээгдэхүүнүүд ялангуяа эдийн засгийн эргэлтэд оруулж чадсан бэ? Патент авсан бэ? Миний мэдэхээр салимоноос өөр бүтээгдэхүүн эдийн засгийн эргэлтэд оруулсан уу. Мөн өнөөдрийн байдлаар ямар ямар бүтээгдэхүүн судалгаа хийж байгаа вэ гэж асууя. Баярлалаа.

Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Кибер аюулгүй байдлын хуулийг баталснаасаа хойш хуультай холбогдуулсан журмуудыг эхнээсээ гаргаад явж байна. Ингээд зөвлөл ажиллаж байна. Ингээд гээд нийтийн төв засгаар байгуулагдсан. Энэ оны төсөв дээр тухайлан төсөв тавигдаж орж ирээгүй хэдий ч бид нар бас сайдынхаа багцын хүрээнд шийдвэрлээд явъя гэдэг ийм л төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Гэхдээ зайлигүй одоо энэ нийтийн төвийг байгуулахад энэ байгууллагад ажиллах хүн зүгээр Программист ч юм уу эсвэл мэдээллийн технологийн инженерүүд байхдаа чухал биш. Энэ төрийн нэрийн өмнөөс төрийн чиг үүргийг төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэж байгаа учраас энэ өөрөө тухайлсан, төрд тангараг өргөсөн, одоо үүрэг биелүүлсэн ийм төрийн албан хаагч байх ёстой. Тэр ч утгаараа зүгээр нэг ийм систем хөгжүүлдэг алба биш шүү дээ. Тэр нийтийн төвийг хүмүүс бас тэгж андуураад дахиад нэг ай тигийн төв байгуулах гээд байна гэж бодоод байдаг юм шиг байгаа юм. Паблик суурьт бол төрийн өмнөөс чиг үүрэг биелүүлэх гэж байгаа байгууллага. Түүнээс биш тэнд ямар нэгэн систем хөгжүүлэгч программист ажиллахгүй. Ер нь одоо манай яаманд ч бай, ер нь Монголын төр цаашидаа программист ажиллахгүй. Төслийн менежерүүд ажиллана. Албан

даалгавар гаргадаг хүмүүс ажиллана. Систем аналистууд ажиллана. Дата одоо аналистууд ажиллана. Ингээд хуваарь хийлгэсэн ажлыгаа өөрөө таньж мэдээд, даалгавраа хянаад, гүйцэтгэлийг нь хянаад, хүлээгээд авдаг тийм чадамжтай цөөн чадварлаг, бүтээмжтэй төрийн албан хаагч нар манай салбар бэхжих ёстой болохоос биш яам болгон ай ти-ийн төв байгуулаад одоо л бид нар жинхэнэ цахимжих гээд байна гэдэг бодлоосоо салахгүй бол энэ улсын төсөв цаашидаа дийлэх ч үгүй юм билээ. Тийм ч учраас энэ жил бид нар хүний орон тоо нэмээд ч юм уу ажиллахаасаа илүүтэйгээр зүгээр энэ цахимжилтыг зардал гээд энэ бол бүхэлдээ 21 аймаг руу чиглэнэ ээ гэдэг зорилтоор тавьсан. Энэ дотор нийтдээ 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүн дотор цахим аймаг, дүүрэг, сум, аймаг болон бизнесийн үйл ажиллагааны зөвшөөрлүүдийг цахимжуулна. Үйлчилгээг мэдээллийг нь бүртгэж авна.

Тэгэхээр одоо Батшугар даргын хэлсэн тоон гарын үсгийн о нийт түгээлт 900 мянгад хүрсэн бол үүнийг хэрэглээнд нэвтрүүлэх хамгийн чухал байна. Хэрэглээнд нэвтрүүлэхийн тулд “цахим аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж Улаанбаатар хотод 100 үйлчилгээг зүгээр мэдээллээр авдаг байгаа шигээ бүх аймгуудад үйлчилгээгээ, мэдээллээ л ажлаа эхэлдэг. Зөвшөөрөл хүсэх шаардлагагүй шинэ Зөвшөөрлийн хуулийн концепцоороо ажиллая гэж байгаа юм. Ингээд эрүүл мэнд, боловсрол, “цахим аймаг” хөтөлбөр хэрэгжиж чадах юм бол тоон гарын үсгээрээ цахим гэрээ хийдэг, тоон гарын үсгээрээ худалдах худалдан авах гэрээгээ хийдэг, тоон гарын үсгээр үйлчилгээ авдаг, зөвшөөрлөө авдаг ийм болно.

Ингээд орон нутагт сая цахим ур чадварын бэлэн байдлын үнэлгээг хийх гээд манай яам агентлагийн ажлын хэсэг 21 аймгаар ажилласан. Одоо цахим бэлэн байдлын үнэлгээгээ гаргана. Ингээд үнэлгээндээ сууриалаад бид энэ аймаг

цахимжилтад бэлэн байна уу эсэх дээр дүгнэлт гаргаж байгаа. Үүний хүрээнд “цахим аймаг” хөтөлбөр хэрэгжинэ. Ингээд дижитал бичиг үсгийн ур чадварыг хөгжүүлэх үндэсний аяныг зохион байгуулж тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх гэж байгаа. Хэрэглээнд нэвтрүүлэхэд яг хүний амьдралтай шууд холбоотой үйлчилгээнүүдийг л тоон гарын үсгээр авдаг болох юм байна.

Тийм учраас и-Монголд дэргэд хуулийн этгээдтэй холбоотой и-бизнес мн ингээд ажиллаад нийт зөвшөөрлийн цахимжилт руу гүнзгий орж чадах юм бол тоон гарын үсэг маш хурдан хугацаанд өнөөдөр энэ тендер шиг, НДШ-ийн тайлангаа өгдөг шиг хурдан хугацаанд нэвтэрнэ ээ л гэж ойлгож байгаа.

Э.Батшугар: 3 номерын микрофоныг нээе. 3. 1-ийг нээчихсэн байна.

Батшугар гишүүний асуултад хариулъя. БШУЯ-ны Шинжлэх ухаан технологийн инновацын газрын дарга Баттогтох. Тэгэхээр яг эрдэм шинжилгээ, судалгаа, инновацад жилд нэг 9-10 орчим тэрбум төгрөг зарцуулдаг. Ингээд нэг нийтдээ нэг 200-250 орчим төслүүдийг хэрэгжүүлж байгаа юм. Төслүүд бол нөгөө төслийнхөө хэлбэрээс шалтгаалаад янз бүрийн үр дүн гаргадаг. Тэгэхдээ энэ төслүүд дотор инновацын төслүүд нийт санхүүжилтийн нэг 10-20 орчим хувьд нь санхүүжилт хийгддэг байгаа.

Инновацын төслөөс голуу патент, ашигтай загвар, илүү үйлдвэрлэлд нэвтрүүлэх төслүүд гарч байгаа юм. Тэгэхээр тухайлбал та түрүүн дурдсан салимоноос гадна манай химийн хүрээлэнгээс дентафон, нефромон, тонзилмон, ортюдент зэрэг эмийг гаргаад Моност нийлүүлж, үйлдвэрлэлд гаргасан байгаа. Яг үүнтэй адилхан яг Дархан 144 сорт, мөн одоо

вирусийн эсрэг биетийг оношилдог элиза оношлуур гээд манай Биологийн хүрээлэнгээс гэх мэтчилэн нэлээд практикт нэвтэрсэн ажлуудыг дурдаж болно.

Ер нь цаашидаа бид бүхэн 24 онд илүү суурь гэхээсээ илүү хавсарга инновацын төслүүдийн тоог нийт төслүүдийнхээ ихэнх хувьд нь санхүүжүүлэх тийм бодлогын шийдлийг баримталж явж байгаа.

Э.Батшугар: Тэгэхээр тодруулж асуулт асуухад ер нь ШУТ сан дээр сүүлийн 10, 15 жил хамгийн амжилттай инновацлаг 10 бүтээгдэхүүн патент авсан гэвэл та юуг нэрлэх вэ? 10 ч байлаа, 5 бүтээгдэхүүн гэвэл.

3 номерын микрофон.

Д.Баттогтох: Нийт Дархан 144 сортыг дурдаж болж байгаа юм. Тэгэхдээ энэ сорт дахиад сайжруулалт хийгдэж байгаа. Тухайлбал энэ сорт одоо нийт газар тариалангийн тариалж байгаа талбай үндсэндээ 40-өөс дээш хувьд нь энэ сортоор тариалалт хийж байгаа яг манай уламжлалт мэдлэг дээр суурилсан сорт. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ сорт тариалснаар жилд дунджаар нэг 10-13 тэрбум төгрөгийн өгөөжийг улсын төсөвт бий болгож чадаж байгаа гэсэн ийм судалгааны дүн байгаа юм.

Түүнээс гадна элэг шилжүүлэн суулгах хагалгаа яг энэ манай цөм технологийн төслөөр амжилттай хэрэгжүүлсэн. Тэгээд энэ төсөл хэрэгжиж энэ технологи бий болсноороо жилд бараг үндсэндээ нэг 8-16 тэрбум төгрөгийн гадагшаа явж элгээ шилжүүлэн суулгах тэр зардал үндсэндээ дотооддоо үлдэж байгаа ийм жишээ дурдаж болж байгаа.

Мэдээж Элиза саяын оношлуурыг дурдаж болно. Үүнээс гадна яг газрын хаврын чиглэлээр бас манай Хими химийн

технологийн хүрээлэн урьдчилсан ТЭЗҮ гаргасан байгаа юм. Тэгэхээр энэ бол дараагийн хөрөнгө оруулагчтай бодлогын яамтай хамтраад бас хэрэгжүүлэх бололцоотой төсөл гэж дурдаж болж байна.

Тэгээд одоо бид нар бас инновацийн төслөөр дэмжиж байгаа бас олон жишээг дурдаж болно. Ноосыг ашиглаж энэ агаарын бохирдлыг бууруулах шүүлтүүр хийж байгаа технологи байгаа. Энэ технологийн санаачлагч Химийн хүрээлэнд ажиллаж байгаад одоо хувийн хэвшилд шинэчлээд хөрөнгө оруулагч татаад явж байгаа. Ийм гэх мэтчилэн олон яг инновацийн ийм үр дүнгүүдийг бас дурдаж болно.

Э.Батиугар: Баярлалаа. Түрүүн нөгөө нэг тоон гарын үсгийг ард иргэд илүү түгээх ялангуяа энэ И-битийн болоход ди-өргөдөл гомдлын системийг ард иргэдэд яаж илүү одоо түгээх, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх үү гэдэг дээр бас нэмж хариулт авмаар байна.

Тэгэхээр и-Монголиа-аас хариулах уу. Хаанаас хариулах вэ? Батбаатар дарга 3 номерын микрофоныг ахиад нээе.

Батиугар даргын асуултад хариулъя. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга Батбаатар. Цахим гарын үсгийн тухай хууль одоо Инновац, цахим бодлогын байнгын хороон дээр батлагдаад жил гаруйн хугацаа болж байгаа. Энэ хугацаанд нийт 800 гаруй, 900 мянга орчим тоон гарын үсэг иргэдэд олгогдсон ийм мэдээлэл байгаа. Улсын Их Хурлаас ди-парламент, битийн парламент.мн гэсэн цахим сайтуудыг нэвтрүүлж, иргэдээс санал одоо авах ийм системийн журмыг Инновац, цахим бодлогын байнгын хороон дээр ингээд батлагдсан. Улсын Их Хурлаас агентлаг руу холбогдох бичгийг яамаар дамжуулан ирээд иргэдийн санал өгөх боломжийг хангаж ажилла гэсэн ийм чиглэл ирсэн. Энэ

хүрээнд төрийн цахим үйлчилгээний хурдан цэг нийт одоо 130 цэгээр дамжуулан мөн энэ дээр данс тийм тоон гарын үсгийг ашиглан ахмад настнууд зөвхөн гар утсаар ашиглах боломжгүй иргэдийн саналыг авах ийм боломжийг хангаад ингээд ажиллаад явж байгаа.

Байнгын хорооны журмын хэрэгжилтийг бас агентлагийн зүгээс ханган ажиллаж байна.

Мөн иргэдэд Улсын Их Хурлаас нэвтрүүлж байгаа цахим системийг сурталчлах ажлыг сургалт хийх ажлыг бас давхар зохион байгуулан ажиллаж байна. Асуултад хариулж дууслаа.

Э.Батиугар: Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооны гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батиугар миний бие Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ